



GLOBAL ETHICS DAY 2025

Видео контентын удирдамж

Эрхэм хүндэт оюутан та бүхнийг Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ээс 2025 оны Дэлхийн Ёс зүйн өдрийг угтан “Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ёс зүйн үүрэг хариуцлага ба ач холбогдол” сэдвээр зохион байгуулж буй уралдаанд оролцохыг урьж байна.

НЭГ. ЗОРИЛГО

Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан их дээд сургуульд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ёс зүйн үүрэг хариуцлага, үнэт зүйлсийн талаарх мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, энэ талаар нийт оюутан залуус болон нийгмийн бусад оролцогч талуудад сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Их, дээд сургуульд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бакалаврын түвшинд суралцаж буй оюутнууд

ГУРАВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Видео бүтээлд тавигдах шаардлага:

- ✓ Утга агуулга, уран сайхны хувьд зохицолдсон шинэлэг санаа дүгнэлттэй байх
- ✓ Ёс бус үг хэллэг агуулагдаагүй байх
- ✓ Сэдвийн онцлогийг товч, тодорхой тусгаж, мэргэжлийн түвшинд ойртуулан хийсэн, шууд ашиглах боломжтой байх
- ✓ Видео контентын үргэлжлэх хугацаа нь 2-3 минутаас хэтрэхгүй байх
- ✓ Бүтээлийн эх сурвалж, ашигласан медиа (зураг, хөгжим, клип гэх мэт)-ийн зохиогчийн эрхэд хамаарах эрх үүргийг зөрчөөгүй байх

ДӨРӨВ. ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- ✓ ММНБИ нь оюутнуудаас ирүүлсэн видео бүтээлийг дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1-100 хүртэлх оноогоор үнэлнэ.

Шалгуур үзүүлэлт	Оноо буюу (%)	Тайлбар
Сэдвийн агуулга ба нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ёс зүйн үүрэг хариуцлагыг илэрхийлсэн байдал	1-40 оноо (40%)	Ёс зүйн концепц мэргэжлийн үнэт зүйлсийг хэр сайн илэрхийлсэн эсэх
Бүтээлч, шинэлэг байдал	1-25 оноо (25%)	Бүтээлч санаа, агуулгын өвөрмөц байдал
Сошиал хандалтын хувь	1-25 оноо (25%)	Сошиал хандалтын тоо
Техникийн чанар	1-10 оноо (10%)	Дуу, дүрс, эвлүүлгийн чанар

ТАВ: ШАГНАЛЫН САН

Уралдаанд ирүүлсэн видео бүтээлүүдээс эхний 3 байрыг шалгаруулна:

I байр:	Өргөмжлөл, 800,0 мянган төгрөг
II байр:	Өргөмжлөл, 500,0 мянган төгрөг
III байр:	Өргөмжлөл, 300,0 мянган төгрөг

Жич: Уралдаанд байр эзэлсэн видео бүтээлийг ММНБИ-ийн цахим сувгаар дамжуулан гишүүд, олон нийтэд сурталчлан таниулна.

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүлээн авах, хэлэлцүүлэх

- ✓ Видео бүтээлийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны 18:00 цагийн дотор www.wetransfer.com-д байршуулж линкийг ethics@monicpa.mn хаягаар хүлээн авна. */Оролцогчийн овог нэр, сургуулийн хаяг, холбоо барих утасны дугаар (2-оос доошгүй)-ыг тодорхой бичиж ирүүлэх/*
- ✓ Оюутнуудаас ирүүлсэн видео бүтээлийг зохион байгуулагчийн зүгээс үүсгэсэн цахим хуудсанд /event үүсгэх/ 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр оролцогчдоос ирүүлсэн дарааллын дагуу байршуулна.
- ✓ Сошиал хандалтыг тоолохдоо 10 дугаар сарын 09-ний өдрийн 00:00 цагаас эхэлж 72 цагийн хугацаатай буюу 12-ны өдрийн 00:00 цаг хүртэл хугацааг хамруулна.
- ✓ Шалгарсан видео бүтээлийн эзэд (уралдааны оролцогч)-эд олгох шагналыг Дэлхийн Ёс зүйн өдрийг угтан МУИС дээр 2025 оны 10 дугаар сарын 14-нд зохион байгуулагдах Ёс зүйн арга хэмжээний үеэр гардуулна.

ХОЛБОО БАРИХ

ММНБИ-ийн Мэргэжлийн үйлчилгээ, зохицуулалтын хороо

Утас: 7000-7888(503), 88902592

И-мэйл: ethics@monicpa.mn